



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/93

Номгон

Аж ахуйн нэгжийн тооллого  
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “з”, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Засгийн газрын 2025 оны “Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай” 259 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын зардалд Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 5,000,000 (Таван сая) төгрөгийг санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Отгонбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Аймгийн аж ахуйн нэгж байгууллагын тооллогыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Статистикийн хэлтэс (Г.Ганчимэг)-т, тооллогыг заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, тооллогын ажлын тайланг илтгэх хуудсаар тайлагнаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тооллогын комисс (М.Мөнгөнцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010245

Аймгийн Засаг даргын 2026 оны 28 дугаар  
сарын 10 -ны өдрийн 493 дугаар  
захирамжийн 2 дүгээр хавсралт



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН  
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН  
БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

М.Мөнгөнцэцэг

Аймгийн Засаг даргын зөвлөх

Орлогч дарга :

П.Отгонбаяр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд :

С.Байгалмаа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

С.Рэнцэндагва

Татварын газрын дарга

Т.Цэвээндорж

Цагдаагийн газрын дарга

Д.Бат-эрдэнэ

Онцгой байдлын газрын дарга

М.Эрхэмбаяр

Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

Б.Азжаргал

Нийгмийн даатгалын газрын дарга

Ц.Мөнхжаргал

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга :

Г.Ганчимэг

Статистикийн хэлтсийн дарга

оОо

Аймгийн Засаг даргын 2026 оны 29 дугаар  
сарын 10-ны өдрийн 4193 дугаар  
захирамжийн 02 дугаар хавсралт



## УДИРДАМЖ

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого  
зохион байгуулах тухай

### Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “з”, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Засгийн газрын 2025 оны “Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай” 259 дүгээр тогтоолыг үндэслэн аж ахуйн нэгжийн тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулахтай холбогдуулан энэхүү удирдамжид заасны дагуу Үндэсний статистикийн хороотой хамтран харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тооллогын үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

### Хоёр. Ерөнхий үйл ажиллагаа:

2.1. Үндэсний статистикийн хороо, тооллогын улсын комиссоос өгсөн чиг үүрэг удирдамжийн дагуу тооллогын холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

2.2. Тооллогын комиссыг аймаг сумын түвшин байгуулж, хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах.

2.3. Аймгийн тооллогын комиссын гишүүд засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд аж ахуй нэгж, байгууллагыг тооллогод тогтоосон хугацаанд бүрэн хамруулах.

2.4. Сумдын тооллогын комисс хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран ажиллах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжилтийг ханган аймгийн комисст тухай бүр тайлагнах

2.5. Тооллогын үйл ажиллагааны явц, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Үндэсний статистикийн хороо болон Тооллогын улсын комисст тухай бүр тайлагнах

### Гурав. Тусгайлсан үйл ажиллагаа:

3.1. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тооллогын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, танилцуулгыг зохион байгуулах

3.2. Үндэсний статистикийн хорооноос боловсруулан хүргүүлсэн тооллогын сурталчилгаа мэдээллийн материалыг олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулах

3.3.Мэдээлэл цуглуулагч, тооллогын комиссын гишүүдийг ажиллах орчин нөхцөлөөр хангах.

3.4.Сумдын тооллогын комисс тооллогын үйл ажиллагааны явцад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар аймгийн Статистикийн хэлтэс болон Тооллогын комисст тухай бүр мэдээлж, холбогдох арга хэмжээ авч ажиллах.

3.5.Тооллогын үйл ажиллагааны явцад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар Үндэсний статистикийн хороо болон Тооллогын улсын комисст тухай бүр мэдээлж, холбогдох арга хэмжээ авч ажиллах

3.6.Тооллоготой холбоотой авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг боловсруулж, Үндэсний статистикийн хороо болон Тооллогын комисст тайлагнах

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

